

**“МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ”-ИЙН ОЛОН НИЙТИЙН
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН ТОВЬЁГ**

Монгол Улсын "Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл"-ийн өөрчлөлтийн төсөл боловсруулахтай холбогдуулан дунд хугацааны төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах, иргэдийн санал, санаачилгыг төсөвт тусгах боломжийг бүрдүүлэх үүднээс цахим орчинд 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд нээлттэй санал, асуулга явуулж нийт 820 гаруй хариулт, 16 задгай санал хүлээн авлаа. Олон нийтээс ирүүлсэн санал, зөвлөмжийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгасан болно.

Нэг. Хэлэлцүүлэх арга хэмжээнд төрийн болон эрдэм шинжилгээний байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил болон иргэдийн төлөөллөөс ирүүлсэн задгай саналын товьёг

Байгууллага, иргэн	№	Санал	Тайлбар
Олон улсын байгууллага	1	Төсвийн орлогын төвлөрлийг нэмэгдүүлэх.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
Иргэн	2	Зардлын үр ашгийг дээшлүүлэх.	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална.
	3	Татварын орлогын тогтвортой байдлыг хангах.	Дунд хугацаанд төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувийг үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгалаа. Ингэснээр хувийн хэвшлийг дэмжсэн татварын шинэчлэл хийгдэх орон зайг бий болгож, хувийн хэвшлийн бизнесээ тэлэх боломжийг бүрдүүлэх, улмаар эдийн засаг

Байгууллага, иргэн	№	Санал	Тайлбар
			дахь төрийн оролцоог үе шаттай бууруулна.
Эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан	4	Төрийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг үнэлж, алдагдалтай байгууллагуудад шинэчлэл хийх.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	5	Төсвийн зарлагыг орлогын боломжтой уялдуулан төлөвлөх шаардлагатай.	Дунд хугацаанд урсгал зардлын хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах бодлого баримтална.
	6	Эдийн засгийн урт хугацааны өсөлтийг дэмжих, бүтээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг төсөвт тэргүүлэх чиглэл болгоход анхаарах.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
Төрийн албан хаагч	7	Гадаад эдийн засгийн орчин, түүхий эдийн үнэ, валютын ханшийн эрсдэлийг тооцож, төсвийн орлого, зарлагын төсөөллийг бодитой боловсруулах.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгав.
	8	Батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд олон удаа тодотгол хийх нь төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	9	Төсвийн алдагдлыг бууруулахын тулд зардлын бүтцийг оновчлох, үр ашиггүй зардлыг бууруулах тодорхой арга хэмжээг тусгах.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д “төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж заасан. ДХТХМ боловсруулахдаа хуулийн шаардлагыг хангаж боловсруулав.

Байгууллага, иргэн	№	Санал	Тайлбар
	10	Төсвийн төлөвлөлтөд суурь болон эрсдэлийн хувилбарыг ашиглаж, орлогын тасалдал үүсэх тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээг урьдчилан тодорхойлох.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	11	Төсвийн хөрөнгө оруулалтыг эрэмбэлж, эдийн засаг, нийгэмд өгөөж багатай төслүүдийн зардлыг хянах.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
Хувийн хэвшил	12	Түүхий эдийн үнийн төсөөллийг олон улсын байгууллагуудын таамаглал болон дэлхийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хандлагад үндэслэн тогтмол шинэчилж байх.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	13	Томоохон төслүүдийн төсөв, санхүүжилтийн мэдээллийг ил тод болгож, улсын төсөвт үзүүлэх ачааллыг бодитой тооцох.	Дунд хугацаанд хэрэгжих томоохон төслүүдийн нөлөөг дотоодын нийт бүтээгдэхүүний барилга, боловсруулах үйлдвэрлэл, эрчим хүч болон бусад салбарын үзүүлэлт, гадаад худалдааны үзүүлэлтийн төсөөлөлд тусгасан.
	14	Төсвийн мэдээллийг иргэдэд илүү ойлгомжтой, нээлттэй хэлбэрээр хүргэж, ил тод байдлыг нэмэгдүүлэх.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	15	Төсөв боловсруулах үйл явц, орлого болон зарлагын тооцооллыг ил тод болгож, үндэслэл мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх.	Саналыг хүлээн авч, төсөв боловсруулах үйл явц, орлого, зарлагын тооцооллын үндэслэл, холбогдох мэдээллийг олон нийтэд нээлттэй, ойлгомжтой хүргэхэд анхаарч ажиллана.
Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	16	Төрийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд хурдан, шуурхай хүргэхийн	Дунд хугацаанд төрийн албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог оновчлох, нийгмийн халамжийн

Байгууллага, иргэн	№	Санал	Тайлбар
		зэрэгцээ төрийн зардлыг бууруулах. Төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоонд үнэлгээ хийж, үр ашиггүй зардлыг бууруулах.	үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийг зохистой түвшинд олгох, төрийн үр ашиггүй зардлыг бууруулах бодлого баримтална.